

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(01-12)

**АНГЛИ ХЭЛНИЙ ҮЙЛТ НЭРИЙГ
МОНГОЛ ХЭЛНЭЭ ИЛЭРХИЙЛЭХ НЬ**

М. Алтанцэцэг*
Ц. Бүүвэйбаатар*

Товч агуулга: Англи хэлний үйлт нэрийн янз бүрийн хэлбэрийг монгол хэлний үйлт нэр буюу цагт нэрийн айтай харьцуулан хэлний энэ нэгжийн хэл зүйн хэлбэр, утга, үүрэг, хэрэглээ, орчуулах арга барилын онцлог зэргийг авч үзлээ.

Түлхүүр үг: үйлт нэр, үйлт нэрийн хэлхэц, үйлт нэрийн хэлбэр, үйлт нэрийн цаг, үйлт нэрийн идэвхтэй хэв, үйлт нэрийн идэвхгүй хэв.

Даяаршиж буй нийгмийн нөлөөгөөр англи хэлний хэрэглээ өсөн нэмэгдэж их дээд сургуулиудад ерөнхий эрдмийн англи хэл, улмаар мэргэжлийн англи хэлийг үзэх шаардлага зүй ёсоор урган гарч ирж энэ чиглэлийн дагуу англи хэлийг зааж сургах үйл явц хэрэгжсээр байна.

Шинжлэх ухааны холбогдолтой ном зохиолыг гадаад хэлээр уншиж ойлгох чадвар дадал эзэмших нь хэлний бус мэргэжлийн ангийн оюутан сурагчдын хувьд бэрхшээлтэй байдаг асуудлын нэг юм. Оюутнуудтай бичвэр дээр ажиллахад тэд үгийн утгыг мэдэх боловч өгүүлбэр дэх үгийг холбон гол санааг иэрхийлж гаргаж чадахгүй байх нь түгээмэл ажиглагддаг. Энэ нь өгүүлбэрт тухайн үг ямар үүргээр орж байгаа, өөрөөр хэлбэл үгийн сан, өгүүлбэр зүй, утга зүй зэрэг хэлний янз бүрийн түвшинд хам сэдвийн хүрээнд холбон ойлгож чадахгүй байгаатай холбоотой юм. “Хэл зүйн утга нь байрлалд шүтэж, байрлал нь холбоход шүтэх тул бүтцийн утга, холбохын утга нь харилцан нягт шүтэн барилдсан зүйл”¹ гэж академич Ш.Лувсанвандан бичжээ. Энэ нь өгүүлбэрт тухайн үг хам сэдвээс хамаарч янз бүрийн утга-үүргээр орж байгааг сайтар ойлгож, зөв оноон орчуулах шаардлагатай гэсэн үг юм.

Иймд бид шинжлэх ухаан техникийн холбогдолтой ном зохиол унших явцад тааралддаг хэл зүйн болон өгүүлбэр зүйн ойлгоход бэрхшээлтэй тохиолдлууд, тухайлбал англи хэлний үйлт нэр(*Participle*)-ийн хэлбэр, өгүүлбэр дэх үүргийг монгол хэлнээ хэрхэн дүйлгэх арга зам, зүй зохистой хувилбарыг илрүүлэн олох зэргээр үйлт нэрийг хэрхэн хэрэглэх болон заах аргыг авч үзэхийг зорилоо.

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Гадаад хэлний төв

¹ Ш.Лувсанвандан (1979), *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн асуудал*, Хэл зохиол судлал, 21-р боть, Улаанбаатар, 153-р тал.

Гадаад хэл заахад бичвэрийг уншиж ойлгож сургах олон арга барил байдаг. Нэг нийтлэг арга нь суралцагчдыг өгүүлбэрийн гол гишүүдийг олж тодорхойлох, юуны түрүүнд өгүүлэхүүнийг (өгүүлбэрт орж байгаа байрлал өгүүлэхүүнтэй зохицох ёс) улмаар хэлбэрийн шинжээр нь өгүүлбэрийн бусад гишүүдийг тогтоон тодорхойлох явдал юм. Зарим үед үгийн сан – хэл зүйн задлал хийхэд хүргэдэг. Энэ санааг тухайлбал И.Р.Рахманинов “текст анализыг хэл зүйн хэлбэр бүтцээс эхлэх нь зүйтэй. Учир нь гадаад хэлээр байгаа текст нь Л.В. Щербагийн баталснаар “утга бол анхдагч” иймээс түүнээс ангид авч үзэх аргагүй”² гэжээ.

Бид энэ өгүүлэлдээ англи-монгол хэлний үйлт нэр ба үйл нэрийн зарим хэлхэцийг харьцуулах судлагдахуун болгож авлаа. Мөн загвар жишээ өгүүлбэрүүдийг аль болох олон салбар шинжлэх ухааны ялангуяа байгалийн шинжлэх ухааны мэргэжлийн холбогдолтой ном зохиолуудаас түүвэрлэн авч анализ хийхийг оролдов. Англи-монгол хэлний өгүүлбэр зүйд хэдий ижил төстэй хэлбэрүүд байдаг боловч зөвхөн тухайн хэлнийхээ онцлогийг илэрхийлэх зүй тогтол ч мөн байдаг билээ. Тухайлбал хоёр хэлний үйлт нэрийн хэлбэр, өгүүлбэрт гүйцэтгэх үүргийн онцлогуудыг харьцуулан авч үзье. Англи хэлний үйлт нэр (Participle)-ийн талаар одоо хир хэл шинжлэлд нэр томъёоны талаар маргаантай санал зөрөөнтэй байсаар байна. Англи хэлний Participle-ийг “үйлт нэр” (participle), “нөхцөлт үйл үг” (participle), “үйл нэр” (gerund) гэх мэтээр монгол хэлнээ олон янзаар нэрлэжээ. Иймд бид цаашид англи хэлнээ **“Participle”**, орос хэлнээ **“Причастие”**, монгол хэлнээ **“Үйлт нэр”** гэж авч байсан уламжлалт нэр томъёог уг өгүүлэлд баримталсан болно. Англи хэлний үйлт нэрийн янз бүрийн хэлбэрийг монгол хэлний үйлт нэр буюу цагт нэрийн айтай харьцуулан хэлний энэ нэгжийн хэл зүйн хэлбэр, утга, үүрэг, хэрэглээ, орчуулах арга барилын онцлог зэргийг авч үзье. Англи монгол хэлний үйлт нэрийн талаар эрдэмтэн судлаачид нэлээдгүй бичиж олон тодорхойлолт өгсөн байдаг. **“Participle is a word having the characteristics of both verb and adjectives; especially: an English verbal form that has the function of an adjective and at the same time shows such verbal feature as tense and voice and capacity to take an object”**. **“Үйлт нэр нь үйл үг, тэмдэг нэрийн аль алины шинжийг агуулсан үг юм. Ялангуяа англи хэлний үйл нэрийн хэлбэр нь тэмдэг нэрийн шинжтэй байхын зэрэгцээ үйл нэрийн онцлог шинжүүд болох цагийн ай болон тусагдахуунтай байх боломжтой”**.³

Англи хэлний сурах бичигт тайлбарласан гол тодорхойлолтоор бол англи хэлний Participle (үйлт нэр) нь үйл үг, тэмдэг нэр, дайвар үгийн шинжийг хадгалсан үйл үгийн эзэн биегүй хэлбэр юм.

Монгол хэлний үйлт нэр нь бүтээврийн шинжээрээ нилээд өвөрмөц онцлогтой байдаг.

Өгүүлбэр дэх үгсийн хэл зүйн харьцааг бүтээврийн аргаар илэрхийлэх нь хэлний түгээмэл үзэгдлийн нэг юм.

Орчин цагийн монгол хэлний сурах бичгүүдэд үйлт нэрийг дараах байдлаар тодорхойлжээ.

1966 онд хэвлэгдсэн “Орчин цагийн монгол хэл” номонд **“Орчин цагийн монгол хэлэнд үйлийн явцын зэрэгцээгээр уул юмын бэлгэ тэмдэг буюу үйлийн эзнийг**

²) Методика и лингвистика. Издательство “Наука”, Москва, 1981.

³) Adrian Doff, Teach English. Cambridge University press. 1991.

заадаг нэр үг, үйл үг хоёрын аль алины шинжийг хадгалсан бүлэг үйл үгийг үйлт нэр гэнэ⁴⁾ гэжээ.

Ц. Өнөрбаяны “Орчин цагийн монгол хэлний үг зүй” (УБ 1998)-д “Монгол хэлний зүйн ном зохиол, сурах бичигт “үйлт нэр”, “тэмдэг үйл”, “цагт нэр” зэрэг нэрийн доор утга үүргийг нь тодорхойлсоор ирсэн -сан⁴, -аа⁴, -х, -даг⁴, -саар⁴, -хуйц² зэрэг дагаварыг тодотгон холбох нөхцөл гэнэ. Эдгээр нөхцөл нь үйл үгийг нэр үгтэй холбож, тухайн үйл үг нь холбогдох нэрийнхээ тодотгол болдог. Энэ нь эдгээр нөхцөлийн үндсэн үүрэг юм. Ийм учраас эдгээрийг үйлийн тодотгон холбох нөхцөл гэж нэрлэж байгаа юм”⁵⁾

Өвөр монголын эрдэмтэд орчин цагийн монгол хэлний сурах бичигт “үйл хөдөлгөөнийг заахын хамт хэрэг юмын бэлгэ чанар, шинж тэмдэгийг зааж чаддаг, тусгай зүүврээр илэрсэн үйл үгийг тэмдэг үйл гэнэ. Тэмдэг үйл үг бол нэрийн чанартай үйл үг юм. Энэ аймаг үг бол тэмдэг нэр, жинхэнэ үйлийн аль алины онцлогийг заримдаг хадгалсан “завсрын” чанартай үг юм⁶⁾ гэх мэтээр томъёолжээ. Мөн академич Ш.Лувсанвандан багш “цагт нэр” гэж нэрлэсэн байдаг.

Үүнээс үзэхэд хэлний аливаа нэгжийн хийсвэр шинж янз бүр байхын хэрээр судлаачид өөрсдийн судалгааны чиг хандлагаасаа шалтгаалаад нэг зүйлийг өөр өөрөөр нэрлэсэн бололтой. Тэгэхлээр үйлт нэр гэдэг нь нэр, үйл, тэмдгийн аль алины шинжийг агуулснаараа онцлог бөгөөд хэл зүйн хэлбэр, утга, үүргээрээ өмнө дурдсан үгсийн аймгийн шинжүүдийг илтгэдэг байна. Хэл шинжээчдийн үйлт нэрийн талаархи тодорхойлолтууд нь хоёр хэлний үйлт нэрэнд заах шинж, өгүүлбэр зүйн үүргийн хувьд ижил төстэй зүйл нилээд ажиглагдаж байна. Үйлт нэрийн өгүүлбэр зүйн гол үүрэг нь үйл үгийг нэр үгтэй тодотгож холбодогт оршино.

Тэмдэг нэрийн шинжийг агуулдгийн хувьд үйлт нэр нь нэр үгэнд тодотгол болж ордог. Энэ үүргээрээ англи хэлний үйлт нэр нь монгол хэлний үйлт нэртэй тохирч байна.

1. Beyond these **limiting** conditions laminar flow, the flow becomes turbulent. Ламинар урсгалын эдгээр **хязгаарлагдсан** нөхцөлийн цаана урсгал ширүүсдэг.

2. Atoms are composed of a positively **charged** ventral core or nucleus and electrons. Атом нь эерэг **цэнэгтэй** цөм ба электронуудаас бүрддэг.

Монгол хэлэнд үйлт нэр нь нэрийг дангаараа дэлгэрүүлэхээс гадна хамжсан тодотгол гишүүн өгүүлбэрийн хэлбэрээр ч дэлгэрүүлдэг. Энэ хоёр өгүүлбэрт **хязгаарлагдсан** гэсэн үйлт нэр **нөхцөл** гэдэг үгийг тодотгол гишүүнээр нэмэн дэлгэрүүлсэн бол дараагийн өгүүлбэрт атом юунаас бүтдэгийг тодорхойлоход атом нь “**эерэг цэнэгтэй**” гэж тодотгол гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүний үүргээр оржээ. Үйлт нэрээр илэрсэн энэ гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийн цөм, электронууд гэсэн үгсийг тодотгож байна. Англи хэлний **charged** гэдэг нь идэвхгүй хэвийн хэлбэрийг **цэнэглэгдсэн** гэж орчуулахын оронд **цэнэгтэй** гэвэл монгол хэлний найруулгад илүү нийцтэй байна.

Дайвар үгийн шинжийг агуулсан англи хэлний үйлт нэр нь дүр байдлыг тодорхойлсон байц гишүүн болдог. Энэ нь монгол хэлний нөхцөл үйл үгтэй тохирдог.

He sat at the table **thinking**.

Тэр ширээний ард **бодлогоширон** сууж байна.

They sat **looking** at the screen.

⁴⁾ Орчин цагийн монгол хэл, ШУА., Улаанбаатар, 1966.

⁵⁾ Ц.Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үг зүй, Улаанбаатар, 1998.

⁶⁾ Орчин үеийн монгол хэл, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 2005.

Тэд дэлгэц рүү **харан** сууж байна.

Үйл үгийн шинжийг агуулсан үйлт нэр нь

а) тусагдахуун гишүүнтэй байж болдог.

Signing the letter the manager asked the secretary to send it off at once.

Эрхлэгч **захианд гарын үсэг зурчихаад** түүнийг яаралтай илгээхийг нарийн бичгээсээ хүслээ.

б) дайвар үгээр хавсран тодотгуулсан байж болно.

Packing his things quickly, he hurried to the station.

Юм хумаа маш **хурдан баглачихаад** тэр буудал руу яаран явсан.

в) цаг ба хэвийн айттай.

Тусах үйл үг нь идэвхтэй хэвд үйлт нэрийн хоёр, идэвхгүй хэвд гурван хэлбэртэй:

Participle (үйлт нэр) - ийн үүсэх хэлбэр

| Participle | идэвхтэй | идэвхгүй |
|------------------------|------------------------|-------------------------------------|
| Present (одоо цаг) | asking - асууж байгаа | being asked – асуугдаж байгаа |
| Past (өнгөрсөн цаг) | ----- | asked – асуугдсан |
| Perfect (төгссөн цаг) | having asked - асуусан | having been asked – асуугдаж байсан |

Эс тусах үйл үг нь идэвхтэй хэвд үйлт нэрийн гурван хэлбэртэй.

| Participle | Идэвхтэй |
|-----------------------|----------------------------|
| Present (одоо цаг) | Coming - ирдэг |
| Past (өнгөрсөн цаг) | Come - ирсэн |
| Perfect (төгссөн цаг) | Having come - ирдэг байсан |

Үйлт нэрийг хэрэглэх нь:

Present Participle Active (идэвхтэй хэвийн үйлт нэрийн одоо цаг)

Present Participle Active нь үйл өгүүлэхүүний илэрхийлж байгаа үйлтэй зэрэг болж байгаа үйлийг заана. Хэрэв өгүүлэхүүн нь одоо цагт байвал үйлт нэрийн илэрхийлж байгаа үйл нь одоо цагт, өнгөрсөн цагт байвал үйлт нэрийн илэрхийлж байгаа үйл нь өнгөрсөн цагт, ирээдүй цагт байвал үйлт нэрийн илэрхийлж байгаа үйл нь ирээдүй цагт байна.

Present Participle Active нь гол өгүүлбэрийн өгүүлэхүүний үйлтэй адил цагт болж буй үйлийг заана.

1. She **is looking** at the woman **sitting** at the window.

Тэр эмэгтэй цонхны дэргэд **сууж байгаа** эмэгтэй рүү **харж байна**.

When I entered the room, I **gave** the letter to the woman **sitting** at the window.

Би өрөөнд орж ирээд цонхны дэргэд **сууж байсан** эмэгтэйд **захиа өгөв**.

When you enter the room, you **will give** the letter to the woman **sitting** at the window.

Та өрөөнд орохоороо цонхны дэргэд **сууж байх** эмэгтэйд **захиаг өгөөрэй**.

2. **Knowing** the English language well, he **can translate** newspaper articles without a dictionary.

Тэр англи хэл сайн **мэддэг учир** сонины өгүүллийг толь бичиггүйгээр **орчуулж чаддаг**.

Knowing the English language well, he **was able to translate** newspaper articles without a dictionary.

Тэр англи хэл сайн **мэддэг учир** сонины өгүүллийг толь бичиггүйгээр **орчуулж чадсан**.

Knowing the English language well, he **will be able to translate** newspaper articles without a dictionary.

Тэр англи хэл сайн мэддэг учраас сонины өгүүллийг толь бичиггүйгээр орчуулж чадна.

Дээр дурдсан жишээнүүдээс харахад Present Participle Active нь гол өгүүлбэрийнхээ үйл өгүүлэхүүнтэй цагийнхаа хэлбэрээр зохицохгүй байгаа боловч монгол хэлэнд нэгэн зэрэг болж буй үйлийг зааж байгаагаар буулгана.

Present Participle (одоо цагт байгаа үйлт нэр) гэж нэрлэх нь хэлбэрийн төдий юм. Одоо цагт байгаа үйлт нэр нь ярьж байгаа агшинтай давхцаж байгаа үйлийг мөн илэрхийлдэг. Present Participle Active нь нэр үгийн тодотгол болж хэрэглэгддэг.

Тодотгол болох нь:

1. *Нэр үгийн өмнө орно.*

The **rising** sun was hidden by the clouds.

Мандаж байгаа нарыг үүл халхалсан.

They looked at the **flying** plane.

Тэд нар **нисэж байгаа** онгоцыг харж байна.

2. *Тодотгол гишүүн өгүүлбэр болох үйлт нэрийн хэлхцэд үйлт нэр нь нэр үгийн дараа орно.*

I picked up the letter **lying** on the floor (= **which was lying** on the floor)

Шалан дээр **байсан** захиаг би авсан.

The man **smoking** a cigarette (= **who is smoking** a cigarette) is my brother.

Тамхи **татаж байгаа** хүн бол миний ах.

Present Participle Active нь байц гишүүн болохдоо:

1. Үйлт нэрийн хэлхэц нь *цаг заасан байц* гишүүн болдог. Ийм хэлхэц нь цаг заасан байц гишүүн өгүүлбэртэй адилхан байдаг. Энэ тохиолдолд үйлт нэрийн өмнө **while**, **when** гэсэн холбоос ордог бөгөөд утга нь үйл үгэндээ шингэдэг.

While(when) exploring the Island, they found some plants never seen before.

Арлыг **судалж байхдаа** тэд урьд нь хэзээ ч харж байгаагүй ургамлуудыг олж харжээ.

When going home (= **when I was going** home) I met my brother.

Гэр лүүгээ **явж байхдаа** би ахтайгаа тааралдсан.

Байнга давтагддаг үйлийг илэрхийлэхэд **when** холбоосыг үйлт нэрийн өмнө хэрэглэдэг.

When drawing up a contract for the sale of goods it is necessary to give a detailed description of the goods.

Бүтээгдэхүүн борлуулах гэрээг **үйлдэхдээ** бүтээгдэхүүний тодорхойлолтыг зайлшгүй өгөх хэрэгтэй.

Цаг заасан байц гишүүнийг илэрхийлсэн үйлт нэрийн хэлхцэд байгаа одоо цагийн үйлт нэр нь үйл өгүүлэхүүний илэрхийлж байгаа үйлээс өмнө болсон үйлийг мөн илэрхийлж болно.

Throwing through a conductor the current heats it. Гүйдэл дамжуулагчаар **урсах үедээ** түүнийг халаадаг.

2. Үйлт нэрийн хэлхэц нь *шалтгаан заасан байц* гишүүн болдог.

Knowing English well (= **As he knew** English well) he translated the article without a dictionary.

Тэрээр англи хэл сайн мэддэг **байсан учраас** өгүүллийг толь бичиг хэрэглэлгүй орчуулсан.

Pilots could fly jet airplanes quite successfully **having** new instruments at their disposal.

Шинэ багаж хэрэгслийг **эзэмшсэнээр** тийрэлтэт онгоцыг амжилттай жолоодож чадсан.

3. Үйлт нэрийн хэлхэц нь *дүр байдал заасан байц* гишүүн болдог.

He sat in the armchair **reading** a newspaper.

Тэр сонин **уншаад** сандал дээр сууж байсан.

Perfect Participle Active (Идэвхтэй хэвийн үйлт нэрийн төгссөн цаг)

Perfect Participle Active нь байц гишүүний үүрэг гүйцэтгэхдээ үйл өгүүлэхүүний илэрхийлж байгаа үйлээс өмнө болж байгаа үйлийг заана.

Энэ үйлт нэрийн хэлхэц нь шалтгаан заасан байц гишүүн хийгээд байц гишүүн өгүүлбэр байж болно.

Having fulfilled the terms of the contract (= **As we had fulfilled** the terms of the contract) we refused to admit the claim of the firm.

Гэрээний нөхцөлийг **биелүүлсэн учраас** бид пүүсийн гомдлыг хүлээж авахаас татгалзсан.

Perfect Participle Active нь цаг заасан байц гишүүний үүргээр ордог. Энэ тохиолдолд үйлт нэрээр илэрхийлэгдэж байгаа үйл нь гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүний илэрхийлж байгаа үйлээс өмнөх үйлийг илтгэдэг.

Having collected all the material (= **After he had collected** all the material), he was able to write a full report on the work of the commission.

Бүх материалаа **цуглуулсны дараа** тэр комиссын ажлын талаар тодорхой тайлан бичиж чадсан.

Шууд дараалж болсон хоёр үйлийн тухай өгүүлэхдээ үйлт нэрийн илэрхийлж байгаа үйл нь үйл өгүүлэхүүний үйлээс өмнө болсныг онцлох шаардлагагүй учраас үйлт нэрийн төгссөн цаг биш, харин үйлт нэрийн одоо цаг хэрэглэдэг. Гишүүн өгүүлбэрт үйл үг нь тодорхойгүй цагт хэрэглэгддэг:

Arriving at the school (= **When we arrived** at the school) we went straight to the class.

Бид сургууль дээрээ **ирэнгүүт** шууд анги руугаа явсан.

Present Participle Passive (Идэвхгүй хэвийн үйлт нэрийн одоо цаг)

Present Participle Passive нь идэвхгүй хэвийн одоо цагт байгаа үйлт нэрийн хэлхцэд тодотгол гишүүн хийгээд тодотгол гишүүн өгүүлбэрээр ордог. Ийм тохиолдолд үйлт нэрийн одоо цаг нь одоо энэ агшинд болж байгаа үйлийг илэрхийлэх утгаар хэрэглэгддэг. Өөрөөр хэлбэл гишүүн өгүүлбэрт одоо үргэлжилж байгаа цагийн идэвхгүй хэлбэрийг хэрэглэдэг.

The large building **being built** in our street (= **which is being built** in our street) is a new school-house.

Манай гудамжинд **барьж байгаа** том байшин бол сургууль юм.

Yesterday the professor told us about the experiments now **being carried** on in his laboratory (= **which are now being carried** on in his laboratory).

Өчигдөр профессор одоо түүний лабораторид **хийж байгаа** туршлагын тухай бидэнд ярьсан.

Present Participle Passive нь үйлт нэрийн хэлхцэд шалтгаан ба цаг заасан байц гишүүн хийгээд байц гишүүн өгүүлбэр болдог.

Being packed in strong cases (= As the goods **were packed** in strong cases), the goods arrived in good condition.

Бат бөх хайрцганд **хийгдсэн болохоор** бараа гэмтээгүй байсан.

Being asked (when he was asked) whether he intended to return soon, he answered that he would be away for about three months.

Удахгүй буцаж ирэх бодолтой эсэхийг түүнээс **асуухад** тэрээр гурван сар орчим байхгүй гэж хариулсан.

Энэ тохиолдолд идэвхгүй хэвийн үйлт нэрийн одоо цагийн зэрэгцээ үйлт нэрийн өнгөрсөн цаг үргэлж хэрэглэгддэг.

Being packed in strong cases... = **Packed** in strong cases ...

Being asked whether ... = **Asked** whether ...

Past Participle Passive (Идэвхгүй хэвийн үйлт нэрийн өнгөрсөн цаг)

Past Participle Passive нь нэр үгийн тодотгол болдог:

1. *Нэр үгийн өмнө:*

Atoms are composed of a **positively charged** ventral core or nucleus and electrons.

Атом нь **зэрэг цэнэгтэй** цөм ба электронуудаас бүрддэг.

2. Үйлт нэрийн хэлхцэд нэр үгийн дараа орж тодотгол гишүүн өгүүлбэрийн үүргээр хэрэглэгддэг. Гишүүн өгүүлбэрийн үйл үг нь идэвхгүй хэвд байдаг.

The units **used** to measure time, space and mass are called fundamental units.

Цаг хугацаа, орон зай, массыг хэмжихэд **хэрэглэдэг** нэгжүүдийг үндсэн нэгжүүд гэдэг.

Past Participle - ийг ер нь л байнга болдог үйлийг илэрхийлэхэд хэрэглэдэг. Харин үүнтэй адил гишүүн өгүүлбэрт **Present Indefinite Passive**-ийг хэрэглэх нь зүйтэй.

They send us a list of goods **imported** by that firm (= which **are imported** by that firm).

Тэд пүүсийнхээ **импортлодог** бүтээгдэхүүний жагсаалтыг бидэнд ирүүлжээ .

A thermometer is an instrument **used** for measuring temperature (= which **is used** for measuring temperature).

Термометр бол температурыг хэмжихэд **хэрэглэдэг** багаж юм.

Present Participle Passive нь одоо болж буй үйлийг илэрхийлж байгаа тохиолдолд түүнтэй дүйх гишүүн өгүүлбэрт **Present Continuous Passive** –ийг хэрэглэдэг.

The large building **being built** in our street (= **which is being built** in our street) is a new school – house.

Манай гудамжинд **баригдаж байгаа** том барилга бол шинэ сургууль юм.

Past Participle нь нийлмэл өгүүлэхүүний холбоц үйл үг ба нэр хэсгийн үүргээр ордог.

My pencil **is broken**.

Миний үзэг **эвдэрсэн байна**.

The letters **were typed**.

Захидлыг **хэвлэжээ**.

Past Participle нь үйлт нэрийн хэлхцэд цаг болон шалтгаан заасан байц гишүүний үүргээр хэрэглэгддэг. Эдгээр хэлхц нь байц гишүүн өгүүлбэртэй дүйдэг ба гишүүн өгүүлбэрийн үйл үг нь идэвхгүй хэвд байдаг.

Asked (= **when he was asked**) whether he intended to return soon, he replied that he would be away for about three months.

Түүнээс удахгүй буцаж ирэх эсэхийг **асуухад** тэрээр бараг гурван сар орчим байхгүй байна гэж хариулсан.

Squeezed by ice (= **As the steamer was squeezed** by ice), the steamer could not continue her way.

Хөлөг онгоц мөсөнд **хашигдсан учир** цааш явж чадаагүй.

Цагийн байц гишүүн болох үйлт нэрийн хэлхцэд үйлт нэрийн өнгөрсөн цагийн өмнө **when** холбоосыг хэрэглэдэг:

When asked whether he intended to return soon ...

Past Participle - ийн нэгэн адил **Present Participle Passive** - ийг хэрэглэдэг.

Asked whether he intended to return soon = **Being asked** whether he intended to return soon

Үйлт нэрийн өнгөрсөн цагийн хэлбэр нь **to have** туслах үйл үгтэй хамт төгссөн цагийн хэлбэрүүдийг үүсгэдэг. Энэ тохиолдлыг монгол хэлэнд өнгөрсөн ба ирээдүй цагийн аль алинаар орчуулж болно.

I have read - би уншсан, би уншиж байсан.

I had read - би уншсан, би уншиж байсан.

I shall have read - би уншина

Perfect Participle Passive (Идэвхгүй хэвийн үйлт нэрийн төгссөн цаг)

Perfect Participle Passive нь *шалтгааны ба цагийн байц* гишүүний үүргээр орж үйл өгүүлэхүүний илэрхийлж байгаа үйлээс өмнө болж байгаа үйлийг илэрхийлнэ.

Perfect Participle Passive – ийн **having been bought, having been sent** гэх мэт хэлбэр нь монгол хэлнээ үйлт нэрийн задлаг хэлбэртэй дүйнэ.

Having been sent to the wrong address (= As the letter **had been sent** to the wrong address) the letter didn't reach him.

Захиа буруу хаягаар **илгээгдсэн учир** түүнд хүрээгүй.

Having been dried and sorted (= **After** the goods **had been dried** and sorted) the goods were placed in a warehouse.

Бүтээгдэхүүнийг **хатааж дахин ангилсны дараа** агуулахад хийв.

Perfect Participle Passive - ийг ихэвчлэн **Present Participle Passive** болон **Past Participle** - ээр орлуулж болдог.

Having been sent to the wrong address = Being sent to the wrong address...= Sent to the wrong address...

Present ба **Past Participle** нь тодотголын үүргээр ордог.

Идэвхгүй хэвийн үйлт нэрийн төгссөн цаг заасан **Perfect Participle Passive** - ийн оронд идэвхгүй хэвд байгаа **after** гэсэн угтвартай **gerund** – ын хэлбэрийг хэрэглэж болдог.

Having been dried and sorted the goods were placed in a warehouse. = **After being dried and sorted** the goods were placed in a warehouse.

Нийлмэл тусагдахууны бүрэлдэхүүнтэй хэлхэц.

Хүртэхүйг илэрхийлэх **to see** – харах, **to watch, to observe** - ажиглах, **to notice** - анзаарах, **to hear** - сонсох, **to feel** – мэдрэх гэх мэт үгсийн дараа одоо цагийн үйлт нэрээс бүрдсэн нийлмэл тусагдахуунтай хэлхэцийг хэрэглэдэг.

Нийлмэл тусагдахууны бүрэлдэхүүнтэй үйлт нэрийн хэлхэц гэдэг нь заахын тийн ялгалд байгаа төлөөний нэрийн дараа **Present Participle** орсон бүтэц бүхий хэлхэц юм.

I saw **him running**. I saw him run.

Би түүний **гүйж байгааг** харсан.

I hear **her shouting**. I hear her shout.

Би түүний **хашгирч байгааг** харсан

Him running, her shouting (him run, her shout) - нь нэгэн адил **saw, heard** гэсэн үйл үгийн хувьд нийлмэл тусагдахуун болно. Энэ нь монгол хэлний гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн заахын тийн ялгалаар хэлбэрждэггүйтэй адил байгаа юм. Энэ төрлийн хэлхэцэд мөн **Present Participle Passive** - ийг хэрэглэх тохиолдол байдаг.

The captain watched **the goods being discharged**.

Усан онгоцны ахмад **бараа буулгаж байгааг** ажиглаж байв.

Өнгөрсөн цагийн үйлт нэртэй нийлмэл тусагдахуун. *Өнгөрсөн цагийн үйлт нэртэй нийлмэл тусагдахуун бүхий хэлхэц* гэдэг нь заахын тийн ялгалд буй төлөөний үгийн дараа **Past Participle** орсон хэлхэц юм. Энэ хэлхэцийг дараах байдлаар хэрэглэнэ.

1. *Хүртэхүйг* илэрхийлэх үйл үгс болох **to see** - харах, **to watch** - ажиглах, **to hear** – сонсох зэрэг үйл үгийн дараа.

I heard **his name mentioned** several times during the conversation.

Яриан дундуур би **түүний нэрийг** хэд хэдэн удаа **дурдсаныг** сонссон.

2. *Хүсэл эрмэлзлэл* илэрхийлсэн үйл үгийн дараа

He wants **the work done** immediately.

Тэрээр **ажил** хурдан **дуусаасай гэж** хүсэж байлаа.

3. **to have** үйл үгийн дараа: Уг хэллэг нь **to have** орсон тохиолдолд тухайн үйл өөрөөр нь бус, харин хэн нэгнээр хийгдсэн болохыг заана.

I had **my hair cut** yesterday.

Өчигдөр би үсээ **засуулсан**.

I **shall have** the letters posted immediately.

Би захиаг хэн нэгнээр **явуулчихнаа**.

To have үйл үг нь янз бүрийн хэлбэрээр болон нийлэмжээр хэрэглэгдэж болдог.

I **have shoes mended** in that shop.

Би гутлаа энэ засварын газар **засуулдаг**.

I **am going to have** my hair cut.

Би үсээ **засуулах гэж байгаа**.

I **want to have** the walls of my room **painted**.

Би өрөөнийхөө ханыг **будуулмаар байна**.

Эрхшээлт бус нэрлэхийн тийн ялгалт үйлт нэрийн хэлхэц (The nominative absolute Participial construction)

Англи хэлэнд үйлт нэрийн хэлхэц нь байц гишүүний үүргээр орох хоёр төрөл байдаг.

1. Үйлт нэр нь тухайн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүнд хамаарах үйлийг заасан хэлхэц бүхий:

Knowing English well, **my brother** was able to translate the article without any difficulty.

Англи хэл сайн **мэддэг болохоор** миний ах өгүүллийг ямарч төвөггүй орчуулж чадсан.

2. Үйлт нэр өөрийн гэсэн өгүүлэгдэхүүнтэй хэлхэц бүхий:

Үйлт нэрийн энэхүү хэлхэцийг *эрхшээлт бус нэрлэхийн тийн ялгалт үйлт нэрийн хэлхэц гэж нэрлэсний* учир нь өөртөө (гишүүн өгүүлбэрт) ерөнхий тийн ялгалд бие даасан өгүүлэгдэхүүнтэйг нь хэлж байгаа хэрэг бөгөөд тэр өгүүлэгдэхүүн нь гол өгүүлбэрт хамааралгүй байдаг.

Энэ хэлхэц гэдэг нь өөртөө ерөнхий тийн ялгалд буй нэр үг **it, this** төлөөний үгс болон **there is** хэлхэцийн **there** зэргээр илэрсэн гол өгүүлбэрийн өгүүлэгдэхүүнээс үл хамаарах өөрийн өгүүлэгдэхүүнтэй үйлт нэрийн хэлхэц бөгөөд ямагт таслалаар зааглагддаг. Энэ хэлхэц нь дараах байдлыг илэрхийлдэг.

а) *Цагийн утгыг:* (цаг заасан гишүүн өгүүлбэртэй адил байдаг).

The temperature of the melted ice **is rising** the movement of its molecules is speeded up.

Хайлж буй мөсний температур **нэмэгдэхэд** түүний молекулийн хөдөлгөөн түргэсдэг.

б) *Шалтгааны утгыг* (шалтгаан заасан гишүүн өгүүлбэртэй адилхан байдаг)

The professor being ill (=As the professor was ill), the lecture was put off.

Профессор өвдсөн учир лекц хойшлогдсон.

The pressure **removed**, the air springs back to its original volume.

Даралтыг **буулгахад** агаар анхны эзлэхүүндээ ордог.

There being a severe storm at sea (=As there was a severe storm at sea), the steamer could not leave the port.

Далайд хүчтэй шуургатай **байсан учир** усан онгоц боомтоос гарч чадахгүй байлаа.

в) *Болзох утгыг:*

The charges **being equal and of the same sign**, the two forces will be in the same direction.

Хэрвээ цэнэгүүд **тэнцүү бөгөөд ижил тэмдэгтэй байх юм бол** энэ хоёр хүч нэг чиглэлд үйлчлэх болно.

Үйлт нэрийн энэ хэлхэц нь **with** угтвартай хэрэглэгдэх тохиолдол байдаг.

The total value of Japan's export increased in 2014 as compared with 2013, **with** food stuffs and manufactured goods occupying place an imported in the exports of the country.

2014 оныг 2013 онтой харьцуулахад Японы экспортын барааны нийт өртөг өссөн, **үүнээс** хүнсний болон аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн тухайн улсын экспортын ихэнхийг эзэлж байв.

Gerund (үйл нэр) ба Participle (үйлт нэр) - ийн ялгаа

Англи хэлэнд **Participle** - тэй үүсэх хэлбэрийн хувьд адилхан үйл үгийн нэг хэлбэр бол **Gerund** (үйл нэр) юм.

Үүсэх хэлбэрийн хувьд ялгагдахгүй учир өгүүлбэрт ямар гишүүнээр орж байгааг хэрхэн яаж ялгахыг жишээн дээр авч үзье.

Gerund өгүүлэгдэхүүн болох нь:

Heating the gas increases the speed the molecules.

Хийг **халаах нь** молекулын хурдыг нэмдэг.

Participle I байц гишүүн болох нь:

Gaining or losing electrons, atoms of become ions.

Атом нь электроныг **нэмэх эсвэл алдсанаар** ион болж хувирдаг.

Гол ялгах арга нь тухайн өгүүлбэрт “-ing” - төгсгөлтэй үгнээс гадна өөр ямар нэг үг өгүүлэгдэхүүний үүргээр орж байгаа эсэхээр тогтоож болно. Хэрэв тийм үг байхгүй бол үйл үгийн энэ хэлбэр нь өгүүлэгдэхүүн болж “ Gerund “ байна гэж үзнэ , хэрэв өгүүлэгдэхүүн болох үг байвал үйл үгийн тэр хэлбэр нь байц гишүүний үүргээр орж “ Participle I “ байна гэж үзэх жишээтэй.

Gerund, Participle I аль аль нь мөн *тодотгол* байж болох учир ялгахад төвөгтэй.

Харьцуулбал:

Gerund тодотгол болох нь:

The boiling temperature - **буцлах** температур

Participle I тодотгол болох нь:

the boiling water - **буцалж байгаа** ус

Ялгахын тулд холбогдож байгаа нэр үг нь утгын хувьд учир зүйн холбогдолтой байгаа эсэхийг авч үзэх хэрэгтэй. Учир нь **boiling temperature** гэдгийг **буцалж байгаа температур** гэвэл логик утгагүй байна.

ДҮГНЭЛТ

Англи хэлний үйлт нэрийн янз бүрийн хэлбэрийг монгол хэлний үйлт нэр буюу цагт нэрийн айтай харьцуулан хэлний энэ нэгжийн хэл зүйн хэлбэр, утга, үүрэг, хэрэглээ, орчуулах арга барилын онцлог зэргийг авч үзлээ.

Монгол хэлний үйлт нэр нь бүтээврийн шинжээрээ нилээд өвөрмөц онцлогтой байдаг. Өгүүлбэр дэх үгсийн хэл зүйн харьцааг бүтээврийн аргаар илэрхийлэх нь хэлний түгээмэл үзэгдлийн нэг юм.

Бидний авсан англи жишээг монгол хэл рүү орчуулахад монгол хэлний үйлт нэрийн дээрх онцлог шинжүүд англи хэлэнд ч нэгэн адил илэрч байна. Хоёр хэлний хувьд түгээмэл байгаа үзэгдэл бол үйлт нэр гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн болохдоо ямагт гол өгүүлбэрийн аль нэг нэр гишүүний утгыг нэмэн дэлгэрүүлж байгаагаараа адилхан байна. Жишээ нь:

Gases are composed of a number of molecular particles **moving** at tremendous speed.

Хий нь маш **хурдтай байгаа** молекулын хэсгүүдээс бүрддэг.

The units **used** to measure time, space, and mass are called fundamental units.

Цаг хугацаа, орон зай, массыг хэмжихэд **ашигладаг** нэгжүүдийг үндсэн нэгж гэнэ.

Дээрх хоёр угсарсан нийлмэл өгүүлбэрийн гол өгүүлбэр дэх молекулын хэсгүүд (molecular particles), нэгжүүд (the units) гэсэн үгсийг “ямар?” гэсэн асуултад хариулагдах тодотгол гишүүн өгүүлбэрүүд нэмэн дэлгэрүүлсэн байна.

Монгол хэлний үйлт нэр үндсээрээ байвал ямагт тодотгол гишүүн өгүүлбэр болдогтой англи хэлний жишээ тохирч байгаа юм. Харин үйлт нэрийн хэлбэр нь задлаг хэлбэр болон нөхцөл авсан бүтцээр илэрвэл орон, цаг, болзох, зорилго, шалтгаан, дүрийн байц гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн болдог.

When **flowing through a conductor** the current heats it.

Дамжуулагчаар гүйдэл гүйх үед гүйдэл нь дамжуулагчийг халаадаг.

If given atomic power spaceships will be able to reach other planet.

Хэрэв гариг хоорондын хөлөгт **атомын хөдөлгүүртэй болчихвол** тэдгээр нь бусад гаригт хүрч чадна.

We increased the reaction rate **increasing temperature**.

Температурыг нэмэгдүүлснээр бид урвалын хурдыг нэмэгдүүлсэн.

Дүгнэхэд англи монгол хэлний үйлт нэрийн хэлбэр, өгүүлбэрт гүйцэтгэх үүргээрээ ижил төстэй тал нилээд байгаа боловч англи хэлний үйлт нэрийн идэвхгүй хэлбэр (passive form) нь шинжлэх ухаан техникийн ном зохиолд түгээмэл хэрэглэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Мөн англи хэлний gerund (үйл нэр) нь үйлт нэрийн одоо цаг (Participle D)-тай хэлбэрээрээ ижил байдаг нь утгыг зөв илэрхийлэхэд оюутнуудад бэрхшээлтэй байна.

Иймд англи, монгол хэлний үйлт нэрийн онцлогуудыг бичвэр дээр ажиллах явцдаа анхаарах нь зүйтэй байгаа юм.

НОМЗҮЙ

1. Adrian Doff., *Teach English*, Cambridge University press. 1991.
2. Anthony E., *English language teaching; approach, method, technique*, 2000

3. Raymond Murphy., *English grammar in use*, Cambridge University Press.
4. Галсан С., *Сопоставительная грамматика русского и монгольского языков*, Изд-во Министерство Народного образования МНР. УБ., 1975.
5. Докштейн С.Я., *Практический курс перевода научно-технической литературы*, М., 1995
6. Лувсанвандан Ш., *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн асуудал*, Хэл зохиол судлал, XXI. УБ. 1986.
7. *Методика и лингвистика*, Изд-во “Наука” Москва. 1981.
8. *Орчин цагийн монгол хэл*, ШУА. УБ. 1966.
9. Өнөрбаян Ц., *Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт*, УБ. 1986.
10. Пүрэв-Очир Б., *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй*, Хоёрдугаар дэвтэр. УБ.2001.

ABSTRACT

In this article we have made an analysis of English Participles in Mongolian language and explain why it is important and useful in English language teaching.

We tried to determine its form, structure, some specific features and of its role and meaning both in English and Mongolian languages.

There are general and similar things between English and Mongolian Participle by comparing their formation. Besides this, there are the things with differences, depending on the structure of two languages and its features .

In this article we have noticed the ability to use the language dependent on the ability to bring grammar and vocabulary together. So it must make sense sometimes to teach words which are grammatically linked.